

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улаанбаатар хот дахь гаалийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/225/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улаанбаатар хот
2026 он

Санхүүгийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас:261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: П.Чанцалдулам
Утас:261885 Цахим хаяг: chantsaldulamp@audit.mn
Аудитор: Т.Баасанцэнд
Утас:261628 Цахим хаяг: baasantsendt@audit.gov.mn
Мишээл-Од Аудит ХХК-ийн захирал: Т.Одончимэг
Утас:70169029 Цахим хаяг: info@misheelodaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
4. АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19
5.3 Зөвлөмж	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ГЕГ	Гаалийн ерөнхий газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

УЛААНБААТАР ХОТ ДАХЬ ГААЛИЙН
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.СҮХБААТАР
ТАНАА

2026.02.25 № 06/322
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаанбаатар хот дахь гаалийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

"Цахим Монгол", "Цахим засаг", "Цахим гааль" зорилтуудын хүрээнд гадаад худалдааг хөнгөвчлөх, гаалийн хяналт, бүрдүүлэлтийн хугацааг багасгах зорилгоор импортлогдож буй суудлын автомашины гаалийн мэдүүлгийг цаасаар хэвлэхгүй байх цахим шийдлийг нэвтрүүлсэн нь гаалийн байгууллагын ачаалал, иргэн, аж ахуйн нэгжүүдийн цаг хугацааны зардал буурч, 74,750 автомашины гаалийн бүрдүүлэлтийг цаасгүй хэлбэрээр гүйцэтгэж цахим шинэчлэлд суурилсан ил тод, шуурхай гаалийн хяналтыг хэрэгжүүлэх, "ногоон гааль" бодлогыг хэрэгжүүлсэн үр дүнтэй арга хэмжээг зохион байгуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Улаанбаатар хот дахь гаалийн газар нь улсын хэмжээний гаалийн болон бусад татвар хураамжийн орлогын 49.7 хувийг бүрдүүлдэг бөгөөд тайлант онд улсын төсөвт 3,525,786,140.0 мянган төгрөгийн татварын орлого төвлөрүүлэхээр төлөвлөснөөс 3,240,475,254.5 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, биелэлт 91.89 хувьтай хэрэгжсэн буюу орлогын төлөвлөгөөг дутуу төвлөрүүлсэн байна. Тайлант онд 178,237 удаагийн гаалийн бүрдүүлэлт хийгдэж өмнөх оноос 12 хувиар буурсан мөн 158 зөрчил илрүүлж 684.140.1 мянган төгрөг төвлөрүүлсэн нь өмнөх оноос 46.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Тус гаалийн газрын үндсэн үйл ажиллагаатай холбоотой гаалийн татварын орлого нь тухайн байгууллагын харилцах дансанд бус гаалийн ерөнхий газрын харилцах дансанд төвлөрч, санхүүгийн тайланд тусгагддаггүйгээс шалтгаалан орлогын тулгалт хийхэд хүндрэлтэй асуудлууд үүсч байна.

Бусад асуудал

Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу аудитын мөрөөр хяналт тавих арга хэмжээ буюу өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрт дурдсан асуудлыг шалгагдагч байгууллага хэрхэн хэрэгжүүлж, шийдвэрлэснийг аудитор хянаж, үнэлэх үүрэг хүлээдэг.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	463,365,953.61	382,984,175.71
33	АВЛАГА	861,786.26	1,745,126.01
33500	Бусад авлага	861,786.26	1,745,126.01
33510	Байгууллагаас авах авлага	861,786.26	1,745,126.01
34	УРЬДЧИЛГАА	3,668,620.00	29,346,818.75
34600	Урьдчилж гарсан зардал	3,668,620.00	29,346,818.75
35	БАРАА МАТЕРИАЛ	458,835,547.35	351,892,230.95
35300	Бэлэн бүтээгдэхүүн	293,389,078.63	273,391,889.63
35400	Хангамжийн материал	165,446,468.72	78,500,341.32
35410	Бичиг хэргийн материал	6,825,575.00	1,169,260.00
35420	Аж ахуйн материал	62,049,715.80	24,310,611.16
35440	Түлш, шатах тослох материал	5,396,500.00	5,046,500.00
35470	Бусад хангамжийн материал	91,174,677.92	47,973,970.16
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	9,064,402,811.45	9,056,695,706.63
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	9,064,402,811.45	9,056,695,706.63
39200	Биет хөрөнгө	8,930,094,388.45	8,923,282,283.59
39201	Барилга, байгууламж, орон сууц	6,674,688,581.00	6,681,444,781.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,168,667,369.52)	(1,300,477,694.13)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	46,800,000.00	346,400,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-	(69,172,222.32)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	3,494,054,481.54	4,772,229,262.62
39206	Хуримтлагдсан элэгдэл	(360,876,133.02)	(1,715,670,756.20)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	281,808,252.17	272,207,139.17
39208	Хуримтлагдсан элэгдэл	(38,380,090.00)	(83,678,226.15)
39214	Бусад үндсэн хөрөнгө	20,000,000.00	20,000,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(19,333,333.72)	(0.40)
39300	Биет бус хөрөнгө	134,308,423.00	133,413,423.04
39301	Програм хангамж	2,890,000.00	2,890,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(894,999.96)
39303	Бусад биет бус хөрөнгө	131,418,423.00	131,418,423.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	9,527,768,765.06	9,439,679,882.34
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	37,257,130.70	290,700,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	37,257,130.70	290,700,000.00
41300	Өглөг	37,257,130.70	290,700,000.00
41360	Бусад өглөг	37,257,130.70	290,700,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	37,257,130.70	290,000,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	700,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	9,490,511,634.36	9,148,979,882.34
51	Засгийн газрын хувь оролцоо	9,490,511,634.36	9,148,979,882.34
51100	Засгийн газрын оруулсан капитал	6,849,976,358.38	6,849,976,358.38
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	6,849,976,358.38	6,849,976,358.38
51200	Хуримтлагдсан үр дүн	2,639,085,053.13	2,297,553,301.11
51210	Өмнөх үеийн үр дүн	(1,615,822,037.11)	2,639,085,053.13
51220	Тайлант үеийн үр дүн	4,254,907,090.24	(341,531,752.02)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,450,222.85	1,450,222.85
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	9,527,768,765.06	9,439,679,882.34

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	14,254,376,366.99	12,379,362,351.16
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,912,498,522.99	12,379,362,351.16
120	Нийтлэг татварын бус орлого	3,912,498,522.99	1,641,719,851.16
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,262,770.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,262,770.00	-
120009	Бусад орлого	-	9,813,591.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	3,863,610,568.99	1,599,460,561.16
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	40,625,184.00	32,445,699.00
122	Тусламжийн орлого	-	10,737,642,500.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	10,737,642,500.00
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	10,722,642,500.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	10,722,642,500.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	15,000,000.00
122133	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	15,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	10,341,877,844.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	10,341,877,844.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	10,341,877,844.00	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	9,999,304,276.75	12,714,561,777.57
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9,999,304,276.75	12,714,561,777.57
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,075,636,862.56	11,613,489,620.13
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	7,581,050,248.44	8,153,268,461.42
210101	Үндсэн цалин	3,703,294,149.27	3,220,333,842.13
210102	Нэмэгдэл	1,874,586,200.53	2,576,163,882.52
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,101,706,000.00	1,452,113,959.97
210104	Урамшуулал	901,463,898.64	904,656,776.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	951,982,966.53	1,151,007,780.25
210201	Тэтгэврийн даатгалын зардал	650,136,170.43	759,765,300.00
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	76,406,155.28	145,005,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	39,687,985.74	41,065,000.00
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	37,150,531.20	41,065,000.00
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	148,602,123.88	164,107,480.25
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	75,087,819.28	98,815,885.84
210301	Гэрэл, цахилгаан	47,954,901.66	71,246,106.09
210302	Түлш, халаалт	17,089,973.79	15,375,985.16
210303	Цэвэр, бохир ус	10,042,943.83	12,193,794.59
2104	Хангамж, бараа материалын зардал	58,538,350.00	181,188,039.66
210401	Бичиг хэрэг	33,891,820.00	34,711,890.00
210402	Тээвэр, шатахуун	13,010,000.00	17,861,432.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,008,116.00	2,188,961.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,820,000.00	950,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,808,414.00	41,225,404.90
210408	Бараа материал акталсны зардал	-	84,250,151.76
2105	Нормативт зардал	114,689.52	184,466.60
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	114,689.52	184,466.60
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	64,493,543.00	12,662,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	280,500.00	-
210604	Урсгал засвар	64,213,043.00	12,662,300.00

Улаанбаатар хот дахь гаалийн газрын 2025 оны санхүүгийн тайлан
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	100,070,257.00	102,817,695.99
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	34,925,146.00	55,250,799.60
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,000,000.00	5,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	7,567,740.00	13,271,344.25
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	33,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	52,511,371.00	29,262,552.14
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	244,298,988.79	1,913,544,990.37
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	15,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	880,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	244,298,988.79	1,897,664,990.37
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	923,667,414.19	1,101,072,157.44
2132	Бусад урсгал шилжүүлэг	319,545,344.00	165,467,180.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	319,545,344.00	165,467,180.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	604,122,070.19	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	604,122,070.19	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	935,604,977.44
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	935,604,977.44
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	4,255,072,090.24	(333,199,426.41)
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	165,000.00	6,332,325.61
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	-
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	-	6,258,875.61
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	165,000.00	73,450.00
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	(165,000.00)	(6,332,325.61)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	4,254,907,090.24	(341,531,752.02)

Улаанбаатар хот дахь гаалийн газрын 2025 оны санхүүгийн тайлан
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	10,349,826,949.00	10,722,650,959.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,949,105.00	10,722,650,959.40
120	Нийтлэг татварын бус орлого	7,949,105.00	8,459.40
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,949,105.00	8,459.40
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,949,105.00	8,459.40
122	Тусламжийн орлого	-	10,722,642,500.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	10,722,642,500.00
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	10,722,642,500.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	10,722,642,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	10,341,877,844.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	10,341,877,844.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	10,341,877,844.00	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	9,787,171,722.70	10,715,894,759.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9,787,171,722.70	10,715,894,759.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,863,504,308.51	9,614,822,601.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	7,425,367,201.23	8,153,268,461.42
210101	Үндсэн цалин	2,743,270,872.75	3,220,333,842.13
210102	Нэмэгдэл	2,400,795,438.73	2,576,163,882.52
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,320,907,200.00	1,452,113,959.97
210104	Урамшуулал	960,393,689.75	904,656,776.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,108,527,800.00	1,151,160,300.00
210201	Тэтгэврийн даатгалын зардал	726,574,000.00	759,765,300.00
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	134,207,200.00	145,005,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	65,666,100.00	41,065,000.00
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	36,416,100.00	41,065,000.00
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	145,664,400.00	164,260,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	74,931,619.28	98,815,885.84
210301	Гэрэл, цахилгаан	47,954,901.66	71,246,106.09
210302	Түлш, халаалт	16,933,773.79	15,375,985.16
210303	Цэвэр, бохир ус	10,042,943.83	12,193,794.59
2104	Хангамж, бараа материалын зардал	60,510,102.00	45,572,993.00
210401	Бичиг хэрэг	29,385,290.00	17,797,000.00
210402	Тээвэр, шатахуун	15,000,000.00	16,790,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,008,116.00	2,410,393.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,950,000.00	1,550,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,166,696.00	7,025,400.00
2105	Нормативт зардал	3,285,000.00	-
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,285,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	94,278,110.00	50,995,339.70
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,815,300.00	4,137,800.00
210604	Урсгал засвар	84,462,810.00	46,857,539.70
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	96,604,476.00	114,129,622.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	61,765,635.00	73,189,298.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,000,000.00	5,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	11,005,860.00	19,448,775.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	230,500.00	1,499,068.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,075,000.00	1,530,000.00

Улаанбаатар хот дахь гаалийн газрын 2025 оны санхүүгийн тайлан
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210807	Газрын төлбөр	461,481.00	461,481.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	12,000,000.00	12,968,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	880,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	880,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	923,667,414.19	1,101,072,157.44
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	935,604,977.44
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	935,604,977.44
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	935,604,977.44
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	935,604,977.44
2132	Бусад урсгал шилжүүлэг	319,545,344.00	165,467,180.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	319,545,344.00	165,467,180.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	604,122,070.19	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	604,122,070.19	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	599,912,357.00	6,756,200.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	599,912,357.00	6,756,200.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	599,912,357.00	6,756,200.00
2200	Дотоод эх үүсвэрээр	599,912,357.00	6,756,200.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	599,912,357.00	6,756,200.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(599,912,357.00)	(6,756,200.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-	-
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,849,976,358.38	1,450,222.85	(1,615,822,037.11)	5,235,604,544.12
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	4,254,907,090.24	4,254,907,090.24
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,849,976,358.38	1,450,222.85	2,639,085,053.13	9,490,511,634.36
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(341,531,752.02)	(341,531,752.02)
2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	6,849,976,358.38	1,450,222.85	2,297,553,301.11	9,148,979,882.34

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	10,824,949,000.00	9,787,045,981.96	1,037,903,018.04	90.4
12	Татварын бус орлого	10,824,949,000.00	9,787,045,981.96	1,037,903,018.04	90.4
120	Нийтлэг татварын бус орлого	-	8,459.40	(8,459.40)	-
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	-	8,459.40	(8,459.40)	-
122	Тусламжийн орлого	10,821,622,400.00	9,787,037,522.56	1,034,584,877.44	90.4
122005	Төсвөөс санхүүжих	10,821,622,400.00	9,787,037,522.56	1,034,584,877.44	90.4
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	10,821,622,400.00	9,787,045,981.96	1,034,576,418.04	90.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,821,622,400.00	9,787,045,981.96	1,034,576,418.04	90.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,655,630,700.00	9,621,578,801.96	1,034,051,898.04	90.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	9,117,023,000.00	8,153,268,461.42	963,754,538.58	89.4
210101	Үндсэн цалин	3,418,008,700.00	3,220,333,842.13	197,674,857.87	94.2
210102	Нэмэгдэл	3,405,888,500.00	2,576,163,882.52	829,724,617.48	75.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,340,525,800.00	1,452,113,959.97	(111,588,159.97)	108.3
210104	Урамшуулал	952,600,000.00	904,656,776.80	47,943,223.20	95.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,151,160,300.00	1,151,160,300.00	-	100.0
210201	Тэтгэврийн даатгал	759,765,300.00	759,765,300.00	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	145,005,000.00	145,005,000.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	41,065,000.00	41,065,000.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	41,065,000.00	41,065,000.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	164,260,000.00	164,260,000.00	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	105,531,100.00	98,815,885.84	6,715,214.16	93.6
210301	Гэрэл, цахилгаан	75,802,800.00	71,246,106.09	4,556,693.91	94.0
210302	Түлш, халаалт	16,356,300.00	15,375,985.16	980,314.84	94.0
210303	Цэвэр, бохир ус	13,372,000.00	12,193,794.59	1,178,205.41	91.2
2104	Хангамж, бараа материалын зардал	54,192,100.00	45,572,993.00	8,619,107.00	84.1
210401	Бичиг хэрэг	18,965,700.00	17,797,000.00	1,168,700.00	93.8
210402	Тээвэр, шатахуун	17,287,600.00	16,790,000.00	497,600.00	97.1
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,988,400.00	2,410,393.00	1,578,007.00	60.4
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,994,100.00	1,550,200.00	443,900.00	77.7
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,956,300.00	7,025,400.00	4,930,900.00	58.8
2105	Нормативт зардал	2,986,300.00	-	2,986,300.00	-
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,986,300.00	-	2,986,300.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	76,534,700.00	57,751,539.70	18,783,160.30	75.5
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,894,000.00	10,894,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	65,640,700.00	46,857,539.70	18,783,160.30	71.4
2107	Томилолт, зочны зардал	340,000.00	-	340,000.00	-
210702	Дотоод албан томилолт	340,000.00	-	340,000.00	-

Улаанбаатар хот дахь гаалийн газрын 2025 оны санхүүгийн тайлан
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	150,309,800.00	114,129,622.00	36,180,178.00	75.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	101,707,100.00	73,189,298.00	28,517,802.00	72.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	7,645,900.00	5,000,000.00	2,645,900.00	65.4
210803	Даатгалын үйлчилгээ	21,945,200.00	19,448,775.00	2,496,425.00	88.6
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,649,800.00	1,499,068.00	150,732.00	90.9
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	264,500.00	33,000.00	231,500.00	12.5
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,530,000.00	1,530,000.00	-	100.0
210807	Газрын төлбөр	599,400.00	461,481.00	137,919.00	77.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	14,967,900.00	12,968,000.00	1,999,900.00	86.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	880,000.00	880,000.00	-	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	880,000.00	880,000.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	165,991,700.00	165,467,180.00	524,520.00	99.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	165,991,700.00	165,467,180.00	524,520.00	99.7
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	165,991,700.00	165,467,180.00	524,520.00	99.7
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	240	211	29	87.9
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	240	211	29	87.9
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	209	181	28	86.6
620003	Үйлчлэх ажилтан	30	29	1	96.7

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Улаанбаатар хот дахь гаалийн газар нь хариуцсан нутаг дэвсгэрийн хүрээнд гаалийн болон бусад татвар хураамжийг ногдуулах, хураах, тэдгээрт хяналт тавих үйл ажиллагаа явуулдаг, Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Тус гаалийн газрын зорилго нь мэргэшсэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэх замаар байгууллагын чадавхыг бэхжүүлэх, үндэсний аюулгүй байдлыг хангаж, эдийн засгийн өрсөлдөх чадварыг дэмжих, олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, улсын төсвийн орлогыг бүрдүүлэхэд оршино.

Гаалийн газрын стратеги зорилтууд:

1. Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах;
2. Улсын хилээр хууль бусаар бараа, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэхтэй тэмцэх;
3. Улсын төсвийн орлогыг шудрага, үр ашигтай, үр дүнтэй бүрдүүлэх;
4. Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадварыг бэхжүүлэх юм.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Улаанбаатар хот дахь гаалийн газар нь Авлигын эсрэг хууль, Гаалийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн аудитын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Татварын ерөнхий хууль, Шилэн дансны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Гаалийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам зэрэг хууль эрх зүйн баримт бичгийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант онд Гаалийн газрын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Гадаад тариф, гаалийн татварын тухай хууль;
- Гаалийн улсын байцаагчийн ёс зүй дүрэм
- Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай;
- Засгийн газрын 2024 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 238 дугаар тогтоол.
- Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”
- Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалт зохион байгуулах журам
- Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журмыг баталсан.
- Гаалийн байгууллагын мэдээллийн аюулгүй байдлын журам

Гаалийн газрын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Шалгагдагч байгууллагад дотоод хяналт хариуцсан ажилтан, дотоод хяналтын нэгж байхгүй бөгөөд Гаалийн ерөнхий газрын хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас тайлант хугацаанд хяналт шинжилгээ үнэлгээ хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улаанбаатар хот дахь гаалийн газрын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус гаалийн газар нь Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны А/272 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон боловч шинэчлэгдсэн заавар, журмыг тусгаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Улаанбаатар хот дахь гаалийн газрын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 88,088.9 мянган төгрөгөөр буюу 1.0 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	861.8	1,745.1	883.3
Урьдчилж төлсөн зардал	3,668.6	29,346.8	25,678.2
Бараа материал	458,835.5	351,892.2	(106,943.3)
Үндсэн хөрөнгө	9,064,402.8	9,056,695.7	(7,707.1)
Нийт хөрөнгө	9,527,768.7	9,439,679.8	(88,088.9)
Богино хугацаат өр төлбөр	37,257.1	290,700.0	253,442.9
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	9,490,511.6	9,148,979.8	(341,531.8)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	9,527,768.7	9,439,679.8	(88,088.9)

Дээрх хүснэгтээс харахад, өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо дансдууд байна. Үүнд:

Урьдчилж төлсөн зардал дансны үлдэгдэл 25,678.2 мянган төгрөгөөр өссөн нь автотээврийн хэрэгслүүд болон хөдөлгөөнт рентген тоног төхөөрөмжид даатгалын үйлчилгээг 1 жилийн хугацаатай хийлгэсэн ба төлбөрийг гэрээний дагуу бүтнээр төлж, сар бүрээр зардлыг хүлээн зөвшөөрч бүртгэсэнтэй холбоотой байна.

Бараа материал дансны үлдэгдэл 106,943.3 мянган төгрөгөөр буурсан нь Гаалийн газрын даргын 2025 оны А/39 тоот тушаалаар бараа материалын дансанд бүртгэлтэй, цаашид ашиглах боломжгүй болон ашиглалтад тавьж олгосон нийт 81,982.7 мянган төгрөгийн бараа материалыг акталж, данснаас хассантай голлон шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 7,701.1 мянган төгрөгөөр буурсан нь ТӨБЗГ-ын 2025 оны 372 дугаар тогтоолоор 242,022.2 мянган төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг 72,606.7 мянган төгрөгөөр үнэ шинэчлэн тогтоосон, ГЕГ-ын даргын 2025 оны А/387 дугаар тушаалаар

Ханги дахь гаалийн газарт 16,620.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг шилжүүлсэн, тайлант үеийн 288,229.1 мянган төгрөгийн элэгдлийн зардал зэргээс голлон шалтгаалжээ.

Мөн ГЕГ-ын даргын 2025 оны А/31 тоот тушаалаар нийт 299,600.0 мянган төгрөгийн 2 ширхэг автотээврийн хэрэгсэл, А/323 тоот тушаалаар 920,752.4 мянган төгрөгийн 4 ширхэг “Зорчигчийн ачаа тээш шалгах рентген тоног төхөөрөмж”, А/325 тоот тушаалаар 230,000.0 мянган төгрөгийн үнэ бүхий “Мансууруулах, сэтгэгцэд нөлөөлөх бодис илрүүлэгч тандагч багаж” тус тус хүлээн авсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 253,442.9 мянган төгрөгөөр өссөн нь улсын төсвөөс санхүүжилтийг дутуу олгосноос шалтгаалан тендерээр зохион байгуулсан гэрээт ажлын үлдэгдэл төлбөр хуримтлагдсан байна.

Засгийн газрын хувь оролцоо 341,531.8 мянган төгрөгөөр буурсан нь хуримтлагдсан үр дүнгийн хэмжээгээр буурсан байна.

Биет бус хөрөнгөд 450.0 мянган төгрөгийн unicus санхүүгийн программ, 165.0 мянган төгрөгийн архивийн ARMS программ, 875.0 мянган төгрөгийн гааль, татвар, хяналт бүрдүүлэлт, цогц програм, 150.0 мянган төгрөгийн төсөв санхүүгийн програм, 1,100.0 мянган төгрөгийн албан хэрэгцээнд, дотоод үйл ажиллагаанд ашиглагддаг програм хангамж, 150.0 мянган төгрөгийн вальютын самбарт ашиглагддаг програм хангамж, 7,078.2 мянган төгрөгийн камерийн холболтын програм лиценз, 15,768.1 мянган төгрөгийн мэдээлэл технологийн теле хяналт лиценз, 33,418.0 мянган төгрөгийн мэдээлэл технологийн лиценз бүртгэлтэй байна. Нийт программ хангамжийн дүн 59,154.4 мянган төгрөг байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус гаалийн газрын 2025 оны төсвийн төсөлд нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 11,669,922.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 1,640,314.7 мянган төгрөгөөр зардлыг бууруулж 10,029,608.0 мянган төгрөгөөр баталсан нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүйгээс шалтгаалсан байна.

Энэ нь бусдаар гүйцэтгүүлэх зардал, эд хогшил, хангамжийн материал худалдан авах зардлыг хасаж, тэвчиж болох зардлыг санхүүжүүлэхгүй байх бодлогыг хэрэгжүүлсэнтэй холбоотой байна.

Тайлант оны батлагдсан төсвийг 795,341.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгож, 10,824,949.0 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 10,824,949.0 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 10,722,642.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, 935,604.9 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 9,787,045.9 мянган төгрөг буюу 90.4 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 1,010,840.6 мянган төгрөг, гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний зардлыг төсвийг 9,316.2 мянган төгрөг, харуул хамгааллын зардлын төсвийг 17,221.7 мянган төгрөг, ажил олгогчоос олгох тэтгэмжийн зардлын төсвийг 524.5 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70205 Татвар хураалт, орлого бүрдүүлэлт	10,824,949.0	9,787,046.0	1,037,903.0	90.4
2	80101- Үндсэн үйл ажиллагааны зардал	10,560,064.1	9,549,223.5	1,010,840.6	90.5
3	80103- Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	37,401.3	28,085.1	9,316.2	75.1
4	80219-Харуул хамгаалтын зардал	61,491.9	44,270.2	17,221.7	72.0
5	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж	165,991.7	165,467.2	524.5	99.7

Тус гаалийн газар нь тайлант онд төрийн албан хаагчдын 9 хувийн орон тооны цомхтголыг хэрэгжүүлээгүй байна. Тухайн орон тооны цомхотголтой холбоотой саналыг Гаалийн ерөнхий газарт хүргүүлсэн боловч шийдвэр ирүүлээгүй байна.

Хоол унааны хөнгөлөлтийг олгохдоо Гаалийн ерөнхий газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А/193 дугаар тушаалын дагуу нэг өдрийн хоол, унааны хөнгөлөлтийг 30.0 мянган төгрөгөөр тооцон олгож байна. Тайлант оны батлагдсан төсөв 1,340,525.8 мянган төгрөг, гүйцэтгэлээр 1,452,113.9 мянган төгрөг буюу зөрүү 111,588.1 мянган төгрөгөөр хэтэрсэн боловч цалингийн зардлын нийт дүнгээр 963,754.5 мянган төгрөгийн хэмнэлттэй байна.

Гадаад томилолт, арга хэмжээ, сургалт, семинар, хурал, зөвлөгөөнд тус тус зардал гараагүй, хэвлэл мэдээллийн байгууллагатай гэрээ байгуулаагүй, төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Гаалийн ерөнхий газрын даргын тушаалаар баталсан байна. Уг төлөвлөгөөнд нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 290,000.0 мянган төгрөгийн цахилгаан шат суурилуулах ажил, харьцуулалтын аргаар 54,000.0 мянган төгрөгийн харуул хамгаалалтын ажил, шууд худалдан авалтаар 95,450.0 мянган төгрөгийн урсгал зардалтай холбоотой худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 290,000.0 мянган төгрөгийн цахилгаан шат суурилуулах ажлын гэрээ байгуулагдаж, гэрээний дагуу хийгдсэн боловч, санхүүжилт олгогдоогүй, харьцуулалтын аргаар 54,000.0 мянган төгрөгийн харуул хамгаалалтын ажлын гэрээг байгуулж тайлант онд 44,270.2 мянган төгрөгийн зардал, шууд худалдан авалтаар 97,119.8 мянган төгрөгийн үйл ажиллагаатай холбоотой урсгал зардал гарсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Улаанбаатар хот дахь гаалийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Мишээл-Од Аудит ХХК-ийн ахлах аудитор О.Цэндхүү, аудитор М.Цэнд-Аюуш нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг захирал Т.Одончимэг, чанарын хяналтын менежер Э.Энхцэцэг, Санхүүгийн аудитын газрын аудитор Т.Баасанцэнд, аудитын менежер П.Чанцалдулам, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Улаанбаатар хот дахь гаалийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 01/60 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 9,999,469.3 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 99,994.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн. Хуулийн хэрэгжилтийн хүрээнд хязгаарласан заалтуудтай холбоотой зөрчил илрээгүй болно.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардлыг гаргахгүй байх, батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тоцон ажилласан байна. Хуулийн хэрэгжилтийн хүрээнд хязгаарласан 32 заалтуудыг хамруулан горим сорил хэрэгжүүлсэн, аудитаар зөрчил илрээгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 153 мэдээллээс 151 мэдээллийг хуулийн хугацаанд иж бүрэн оруулсан бөгөөд хугацаа болоогүй 2 мэдээлэл байна. Мөн Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 12,194,358.2 мянган төгрөгийн 26 удаагийн орлого, 2,724,216.8 мянган төгрөгийн зарлагын 30 удаагийн мөнгөн гүйлгээг үнэн зөв иж бүрэн байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 3 улирлын санхүүгийн тайланг хамруулж, өмнөх оны зөвлөмжийн биелэлт, мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, цалин хөлс, татварын бүртгэл, өглөг, авлагын данстын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажууллаа. Завсрын аудитаар 39,171.4 мянган төгрөгийн 2 алдааг залруулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар 2,314.0 мянган төгрөгийн 1 хариуцлага тооцох албан шаардлага, 1 зөвлөмж өгнсийг тайлант онд бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	2,314.0	1	2,314.0	100.0
Зөвлөмж	1	-	1	-	100.0
Нийт дүн	2	2,314.0	2	2,314.0	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Улаанбаатар хот дахь гаалийн газрын санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн анхаарал татсан дараах асуудлуудад дараагийн аудитаар горим сорил хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Үүнд:

1. Улаанбаатар хот дахь гаалийн газар нь хариуцсан нутаг дэвсгэрийн хүрээнд гаалийн болон бусад татвар хураамжийг ногдуулах, хураах, тэдгээрт хяналт тавьж, улсын төсвийн орлогыг бүрдүүлэх ажлын хүрээнд тайлант онд 3,240,475,254.5 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, орлогын төлөвлөгөө 8.1 хувиар тасарсан учир аудитын явцад тус гаалийн газрын үйл ажиллагааны үр дүнг үнэлэхтэй холбоотойгоор гаалийн бүрдүүлэлт, түүний төлөлтийг тулган шалгахад 2025 оны эхний хагас жилийн байдлаар 1,731,016,303.0 мянган төгрөгийн ногдуулалтад 1,593,982,591.9 мянган төгрөгийн гаалийн төлбөр төлөгдөж 137,033,711.1 мянган төгрөгийн дутуу төлөлттэй гэж үзсэн. Гэтэл шалгагдагч байгууллага тайлбар ирүүлэхдээ 1,593,982,591.9 мянган төгрөгийн орлого нь 5 харилцах дансаар орсон гүйлгээ ба хоорондын тооцоогоор 449,235.9 мянган төгрөг, Сангийн яамны төрийн сангийн дансаар 2,686,006.5 мянган төгрөг, урьдчилгаа төлөлтөөр 247,550,923.5 мянган төгрөг тус тус орж бүгд 1,844,668,757.8 мянган төгрөгийн орлого төвлөрч 113,652,454.8 мянган төгрөгийн өглөг тайлагнасан гэсэн тайлбар ирүүлсэн ба тус асуудлыг дараагийн аудитаар дахин авч үзэх нь зүйтэй гэж үзсэн;
2. Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа бүх гаалийн байгууллагуудын татвар хураамжийн орлогууд Гаалийн ерөнхий газрын 5 арилжааны банкны дансанд төвлөрдөг

ба үүнээс гаалийн байгууллага бүр өөрт хамаарах орлогын гүйлгээг түүвэрлэн авч тулгалтыг хийдэг байна. Үүнээс шалтгаалан иргэн, аж ахуйн нэгжид ногдуулсан төлбөр төлөгдсөн эсэхийг хянаж, төлөгдөөгүй мөнгө өөр ямар дансанд орсныг хайж олох замаар нарийн төвөгтэй байдлаар нягтлан бодох бүртгэл хөтлөгдөж байна. Эдгээр орлогууд Улаанбаатар хот дахь гаалийн газрын санхүүгийн тайланд тайлагнагддаггүй, Гаалийн ерөнхий газарт гүйлгээ баланс гаргаж нэгтгэдэг байна;

3. Тус гаалийн газар 2025 онд 96 ш автомашин, 100 ш авто аптег, 1 ш тоног төхөөрөмж гэх мэт 197 ш 1,970,259.3 мянган төгрөгийн хөрөнгийг улсын орлого болгон бүртгэснээс 62 ш 871,289.2 мянган төгрөгийн автомашиныг борлуулсан байна. Хураан авсан барааг худалдан борлуулах үүргийг Засгийн газрын 2017 оны 195 дугаар тогтоолоор баталсан “Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслээс хохирол нөхөн төлүүлэх, улсын орлого болгох, устгах журам”-ын дагуу Нийслэлийн засаг даргын дэргэдэх “Эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр хураан авсан хөрөнгө, эд зүйлс, хэрэгслийг үнэлэх, худалдан борлуулах, устгах талаар шийдвэр гаргах, хэрэгжилтэд хяналт тавих” зөвлөлд шилжүүлэн өгч шийдвэрлүүлдэг, Улаанбаатар хот дахь гаалийн газрын санхүүгийн тайланд тайлагнагддаггүй;
4. Аудитад ирүүлсэн үнэт цаасны тооцоо бодолтын баримтын бүрдэл шаардлага хангаагүй учир тооцоог хянаагүй, зэрэг асуудлууд;
5. Сангийн сайдын 2025 оны А/03 тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ыг сайжруулахтай холбоотой дараах саналуудыг хүргүүлж байна. Үүнд:
 - Журмын хоёрдугаар хавсралтаар батлагдсан санхүүгийн тайлангийн маягт болон Сангийн яамны finperform.mof.gov.mn сайт дахь маягт хоорондын зөрүүг арилгах.
 - Журмын гуравдугаар хавсралтаар батлагдсан дансны жишиг жагсаалтыг дээрх Сангийн яамны шинэ сайттай уялдуулах.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 106,855.2 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан.

Залруулсан алдаа:

- Санхүүгийн үр дүнгийн тайлан болон үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн тайлант оны элэгдлийн зардлын дүн 19,988.9 мянган төгрөгөөр зөрүүтэй;
- Үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн "Шилжүүлсэн бүтцийн өөрчлөлтөөр" мөрийн 2,605.1 мянган төгрөгийн дүнг санхүү үр дүнгийн тайланд "Хөрөнгийн дахин үнэлгээний зардал" дансанд (-) тэмдэгтэй тайлагнасан;
- Санхүүгийн үр дүнгийн тайланд 84,261.2 мянган төгрөгийн акталсан бараа материалын зардлыг бараа ажил үйлчилгээний бусад зардал дансанд бүртгэсэн зэрэг алдаа нь УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга стандартын 27-д "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой" гэсэн заалтыг хангаагүй;

Аудитаар илэрсэн 1 зөрчилд² зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 99,994.7 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Биет бус хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Газар эзэмших эрхийн гэрчилгээгээр 1,151 м2 болон 1,168 м2 талбайтай 2 гэрчилгээтэй газруудыг санхүүгийн тайланд 2,321 м2 талбайтай 1 газар гэж тусгасан байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 3 дугаар зүйлийн 3.8-д "Газар эзэмших/ашиглах эрх үүсмэгц түүнийг үнэлж, санхүүгийн тайланд бүртгэх саналыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Газар эзэмших эрхийн гэрчилгээг санхүүгийн тайланд үнэн зөв тайлагнах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/;

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
								Залруулсан		Залруулаагүй	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Санхүүгийн үр дүнгийн тайлан болон үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн тайлант оны элэгдлийн зардлын дүн 19,988.9 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн.	1	19,988.9	1	19,988.9			1	19,988.9		
2	Үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн "Шилжүүлсэн бүтцийн өөрчлөлтөөр" мөрийн 2,605.1 мянган төгрөгийн дүнг санхүү үр дүнгийн тайланд "Хөрөнгийн дахин үнэлгээний зардал" дансанд (-) тэмдэгтэй тайлагнасан.	1	2,605.1			1	2,605.1	1	2,605.1		
3	Санхүүгийн үр дүнгийн тайланд 84,261.2 мянган төгрөгийн акталсан бараа материалын зардлыг бараа ажил үйлчилгээний бусад зардал дансанд бүртгэсэн.	1	84,261.2			1	84,261.2	1	84,261.2		
	Дүн	3	106,855.2	1	19,988.9	2	86,866.3	3	106,855.2		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох албан шаардлага	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Газар эзэмших эрхийн гэрчилгээгээр 1,151 м2 болон 1,168 м2 талбайтай 2 гэрчилгээтэй газруудыг санхүүгийн тайланд 2,321 м2 талбайтай 1 газар гэж тусгасан байна	1	-					1	-		
	Дүн	1	-					1	-		